



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
🌐 <http://rtcc.mrtd.gov.mn>
✉ info@rtcc.mrtd.gov.mn
☎ +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2019 оны наймдугаар сарын дугаар

Төвийн үйл ажиллагаа



Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд:

2019 онд Улсын хэмжээнд төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явагдаж байгаатай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хуваарь, удирдамжийн дагуу ЗТХЯ-ны урьдчилсан үзлэгийн салбар комисст төвийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тайлагнаж ажиллалаа.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 105 дугаар тушаалаар батлагдсан хяналт-шалгалтын ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолд нийцүүлэн “ГТХЗНТ” УТҮГ-ын дотоод хяналтын ажиллах журмыг захирлын тушаалаар батлуулж, нийт ажилтанд танилцуулж байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгжилтийг хангахад ЗТХЯ-наас чиглэл авч ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Зам тээврийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам” боловсруулах ажлын явцыг хэлэлцэх хуралд оролцож, харъяа байгууллагуудын санал, зөвлөмж, туршлагатай танилцлаа.

Салбарын байгууллагуудын ХАБЭА-н журам, хяналтын тогтолцоог судлан тэдгээрийн давуу тал, шинэлэг арга хэмжээнүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, төвийн ХАБЭА-н журмын төслийг боловсруулахаар ЗТХЯ-аас чиглэл авлаа.




Дотоодын судалгаа



“Төвийн мэргэжилтнүүд 129 тушаалын дагуу Толгойт өртөөнд ажиллалаа.”

“ГТХЗНТ” УТУГ-ын мэргэжилтнүүд Зам, тээврийн хөгжлийн сайдын байгуулсан. “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологи нэвтрүүлэх судалгаа, төслийг боловсруулах” ажлын хэсгийн хүрээнд өртөөдийн өдөр тутмын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалттай танилцах, судлах зорилгоор энэ сарын 8 -наас 9-ний өдрүүдэд “УБТЗ” ХНН -ийн Тээвэр зохион байгуулалтын алба, Толгойт өртөөний ажлын байр болон ашиглагдаж байгаа програмуудтай танилцаж судалгаа хийлээ.



Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологи, түүний автоматжуулалт, өртөөний өдөр тутмын ажлын үйл ажиллагааг хэрхэн автоматжуулах, үүнээс үүдэн бий болох ач холбогдлыг судлан тооцохыг зорилго болгон ажиллав.





Төмөр замын сэлгээ хийх төлөвлөгөө, үйл ажиллагаа болон зохицуулалтыг оновчтой болгох “НТК Дижитал Холболтын Систем”-ийн судалгааг хийж байна.


НТК Дижитал Холболтын Систем нь 4G технологи дээр боловсруулсан бөгөөд сэлгээ хийх төлөвлөгөө, үйл ажиллагаа болон зохицуулалтыг оновчтой болгохын тулд сэлгээний ажлын найдвартай байдал, аюулгүй байдал болон үр ашгийг дээшлүүлэх зорилготой.

Уг систем нь хэсэглэл дэх галт тэрэг найруулах төлөвлөгөөг оновчтой болгох зорилготой. Сэлгээний бригад болон өртөө хооронд 4G утасгүй сүлжээг ашиглаж холболтыг хийнэ.

Тусгай зориулалтын 4G утасгүй сүлжээ нь мэдээллийн дэд бүтэц болох үндсэн технологи юм.

2. Системийн бүтэц

Дижитал холболтын систем нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.





Төмөр замын сэлгээ хийх төлөвлөгөө, тээврийн зохицуулалтыг оновчтой болгох “НТК Дижитал Холболтын Систем”-ийн судалгааг хийж байна.

Сэлгээний ажлын найруулагчын гар станц:



Гар станц нь сэлгээний ажлын ахлагч, машинчийн дууг бичлэг хэлбэрээр хадгална.

Оператор гар станцын LED дэлгэцнээс сэлгээ хийх төлөвлөгөө, бичлэгийг үзэх, зураг болон бичлэгийг татаж авах болдог давуу далтай юм.

Гар станцын цэнэг дуусах үед операторт дахин цэнэглэх анхааруулга дохио өгөх болно.

Вагоны сэлгээ хянах төхөөрөмж /вагон дээр байршуулна/:



Вагоны сэлгээ хянах төхөөрөмж нь сэлгэх гэж байгаа вагонууд дээр бэхлэгдэнэ. Энэ нь GPS ашиглан вагоны байрлалыг харуулж сэлгээ хийх үйл ажиллагааг харуулсан видео бичлэг хийх, сэлгээ хийж буй вагон болон хөдөлгөөнгүй байгаа вагон хоорондох зайг лазераар хэмжих технологи ашиглан мэдээлэх боломжтой.



“ГТХЗНТ” УТУГ нь Харбины төмөр замын судалгааны институттэй хамтран монголын төмөр замын салбарт RFID бүртгэлийн системийг нэвтрүүлэх судалгааг хийж байна.

Төвийн мэргэжилтнүүд “БНХАУ-ын НТК Харбины төмөр замын судалгааны институттэй хамтран Монголын төмөр замын салбарт орчин үеийн технологид суурилсан ухаалаг бүртгэл мэдээллийн системийг нэвтрүүлэх судалгааг хийж байна. Судалгааны ажлын гол хэсэг нь RFID технологид суурилсан вагоны хөдөлгөөнийг хянах технологи юм.

Харбины төмөр замын судалгааны институт нь 1990 онд байгуулагдан өнөөг хүртэл төмөр замын тээвэрлэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг илүү үр дүнтэй, зардал бууруулсан, цахимжуулсан ухаалаг шийдлийг нэвтрүүлэн практикт хэрэгжүүлсээр байна.

Жишээ нь: “Хятадын төмөр зам” төрийн өмчит компани 70 мянган км төмөр замыг RFID системээр тоноглож, 800 мянган вагонд чип суурьлуулж, зам дагуу 2000 ширхэг чип уншигч суурилуулсан ба төмөр замын ухаалаг системийн үндсэн суурь болж үр ашигтай ажиллаж байна.

Радио давтамжид суурилсан чипийг төмөр замын салбарт анх 1980 оноос Финлянд, Швед, Өмнөд Африк, Герман, АНУ, Энэтхэг зэрэг орнууд ашиглаж эхэлсэн. Төмөр замын менежмент системийг илүү ухаалаг, тээврийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, аюулгүй болгох зорилгоор RFID технологийг сонгосон нь үр ашигтай, найдвартай болох нь туршилтаар батлагдсан.

RFID insider.com сайтаас төмөр замын салбар дараах ашиг тусыг хүртсэн гэсэн судалгаа хийсэн байна. Үүнд:

- Вагон илрүүлэлт сайжирсан
- Хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн
- Үйл ажиллагааны зардал буурсан
- Хүнээс хамаарсан алдаа буурсан
- Ачаа бараа алдагдах/ хулгайлагдах тоо буурсан
- Логистикийн саатал буурсан

RFID эсвэл IoT /internet of everything/ нь логистикийн салбарт /ялангуяа төмөр зам/ өргөн цар хүрээтэй нэвтэрч байгаагаас үзэхэд RFID ашигладаг төмөр замын менежмент системийн зах зээл нь 2022 оны эцэс гэхэд 5 тэрбум доллар болж өсөх тооцоо гарчээ. АНУ, Канадын төмөр зам нь энэ системээр 3,2 сая вагон тоноглож, 20 000 чип уншигч суурилуулсан байна. ОХУ-д зүтгүүрийн 100%, зорчигчийн вагоны 10%, ачааны вагоны 42%, моторт вагоны 89% нь уг төхөөрөмжөөр тоноглогдсон байна.


RFID системд суурилсан бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээл дээр 2000 онд 900 сая доллар, 2005 онд 2650 сая ам.долларын борлуулалттай болсон нь зах зээлд хамгийн хурдацтай өсөж байгаа технологи болж худалдаа, тээвэр, аж үйлдвэрийн салбарт зонхилон ашиглагдаж, тэдгээрийн үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх, бодит цагийн мэдээлэл дээр тулгуурлан оновчтой шийдвэр гаргах, төлөвлөх, ажлыг хялбарчлах болсон.

Мэдээ, мэдээлэл



Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.



2019 оны 8 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtc-c.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.

Төмөр замын тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх цахим орчинг сайжруулах зорилгоор ЗТХЯ, “АТҮТ” ТӨҮГ-тай хамтран төрийн захиргааны маягуудыг програмын өгөгдлийн санд кодчилон, өрөлт хийж ЗТХЯ БТГ-ын салбарын эдийн засаг, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өглөө.



Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийн 8-р сарын дугаарыг төвийн цахим хуудсанд байршууллаа.

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой “Trains”, “Railway Magazine”, “Railway Age” сэтгүүлийн 8-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.






“Хувь хүний хөгжил ба байгууллагын үр бүтээмж” сэдэвтэй сургалтад төвийн хамт олон хамрагдлаа.

Энэхүү сургалт нь алсын хараа болон зорилготой зөв хамт олныг бүрдүүлэх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үнэ цэнийг бий болгох, стратеги болон цагийн менежментийг зөв хийснээр хувь хүн өөрийгөө идэвхижүүлж, үр бүтээмжээ дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт боллоо.



Мөн ажилтан, албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн мэдлэгийг дээшлүүлэх, баримт бичиг боловсруулах чадварыг сайжруулах зорилгоор “Төрийн албан хэрэг хөтлөлт” сэдвээр сургалт зохион байгуулагдлаа.





**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

